

平成 29 年度 研究成果報告書  
Research Achievement Report FY2017

講座名・職名 Course Title・Job Title	アジア I 講座・特任准教授
氏名 Name	Magsarjav Bayarsaikhan
専門分野 Academic Field	

主たる研究テーマ Principal Research Subject	Монгол хэлний дагавар
--	-----------------------

Төлөвлөсөн дагуу монгол хэлний дагаврын толь бичиг зохиоход шаардлагатай бэлтгэл ажлуудыг гүйцэтгэв.

Үүнд:

1. Өнөөг хүртэл хэвлэгдсэн монгол хэлний үг бүтээх дагавруудын бүртгэл жагсаалт, тэдгээрийн байр, бүтэц, утга, гарлын талаар тухайлан судалсан гол тулгуур бүтээлүүдийг нягтлан үзлээ.
2. Дагаврын судалгаа хийхийн тулд зайлшгүй хийх бэлтгэл ажил бол үүсмэл үгийн сан хөмрөгийг бүрдүүлэх ажил байлаа. Одоогоор ийм судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож 50 000 орчим үгийн монгол бичгийн галиг, кирилл бичлэгийг товч тайлбарын хамт багтаасан цахим файл бэлэн болгоод байна. Энэ файлыг бэлтгэхдээ өмнө нь өөрийн хамтран зохиогчоор оролцон хэвлүүлсэн монгол хэлзүйн толь бичиг ба тонгоруу толь бичгийг суурь болгог ашиглаж, Монгол хэлний их тайлбар толь, Ц.Норжины “Монгол хэлний толь” зэрэг сүүлийн үед гарсан бусад томхон толь бичгийг хяналт болгон харгуулав. Одоо энэ файлаас үүсмэл үгийг нь ялгаж ангилах ажлыг үргэлжлүүлэн хийх болно.
3. Дагаврын толийн бүтэц, зохиомжийг урьдчилсан байдлаар төлөвлөв. Үүнд, үг бүтээх дагаврыг цагаан толгойн дэсээр дараалуулан толилно. Дагавар тус бүрд үндсэн тодорхойлолт, үүсмэл үгийн жагсаалтыг гаргана. Дагаврын тодорхойлолт хэсэгт дагаврын бүтэц, бичлэг, үг бүтээх загвар, үг бүтээх утга, хувилбар бүтээврийн хэлбэрүүдийг нь заавал тодорхойлон бичнэ. Мөн нэгэнтээ тодорхой, маргаангүй гэж үзвэл түүхэн хувьсал, гарлыг нь бичнэ. Үүний дараа тэр дагавраар бүтсэн үүсмэл үгсийн жагсаалтыг бичнэ. Жагсаалтыг гаргахдаа монгол бичгээр хэрхэн бичдэг, монгол бичгийн латин галиг, кирилл бичлэг, үүсмэл үгийн товч утга гэсэн дарааллаар энэ 4 зүйлийг хадаж бичнэ. Түүнээс гадна, тухайн дагавраар буруу бүтээсэн үгс байвал тийм үгсийг мөн жичид нь тайлбарлан бичвэл зүйтэй гэж үзэв.

Товч дүгнэж хэлбэл, 2017 онд төлөвлөсөн ёсоор монгол хэлний дагаврын судалгаа хийх бэлтгэл ажлыг үндсэнд нь хийж дуусгав.